

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулах, төлөвлөсөн хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ГСА-2026/05-6-ШТА-НА

Говьсүмбэр
2026 оны 04 сар

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа, Утас: 70543179
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр,
Утас:70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх
аудитор

Б.Сарантуяа

Аудитын менежер

Г.Наранбаяр

Ахлах аудитор

Б.Дарханбат

Аудитор

С.Батцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70543179 дугаарын
утсаар харилцана уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 213 тоот

2026 оны 04 дүгээр сар

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА. 8

1. А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлэх үйл явц хангалтгүй, олон нийтээр хэлэлцүүлж санал авах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.8
2. А.2. Төлөвлөсөн төсөл арга хэмжээний 10 хувь нь сүүлийн 2 жилийн хугацаанд магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байна.10

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА. 12

3. Б.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу, хугацаанд нь зохион байгуулсан байна.12
4. Б.2 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхэд хяналт, шалгалт хийгээгүй байна.13

ЗАРИМ ТӨСӨЛ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ, ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА. 13

5. В.1 Өмнөх оноос дамжин хэрэгжиж буй зарим төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна.13
6. В.2 Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.15
7. В.3 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлээгүй, бүрэн хүчин чадал зориулалтын дагуу ашиглаагүй байна.17

Дүгнэлт

Зөвлөмж

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ГСА	Говьсүмбэр аймаг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨАГ	Орон нутгийн өмчийн газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХАА	Худалдан авах ажиллагаа
ЭЗНХҮЧ	Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/179 дүгээр тушаал, Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөр, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;
- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Авто замын тухай хууль
- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам” болон холбогдох бусад аргачлал
- Батлагдсан зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ, бусад холбогдох эрхзүйн актууд
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Говьсүмбэр аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 2025 онд хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилт болон аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд болох аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ, захиалагч байгууллагууд, хяналт хэрэгжүүлсэн байгууллагууд, холбогдох бусад гүйцэтгэгч аж ахуй нэгжийг хамруулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, ХАА-ны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт 100, 300, 400, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатыг 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс эхлүүлж, тайланг шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл:

Байхгүй.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймагт 86,288.8 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ баталсан байна.

2025 онд батлагдсан төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртгийн хэмжээг өмнөх онуудтой харьцуулбал:

Он	(сая төгрөгөөр)					
	Шинэ		Шилжих		Нийт	
	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
2025	0	0	10	86,288.8	10	86,287.8
2024	15	89,116.5	7	29,253.1	22	118,369.6
2023	0	-	10	46,357.7	10	46,357.7
2022	4	11,856	6	28,662	10	40,518
2021	2	3,700	7	19,414	9	23,114

Хүснэгтээс харахад: Говьсүмбэр аймагт 2025 онд 86,288.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл, арга хэмжээ шилжих хөрөнгө

оруулалтаар хэрэгжихээр батлагдсан байна. Үүнээс аймгийн Засаг даргад 19,819.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ эрх шилжсэн байна.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд шилжих хөрөнгө оруулалтаар батлагдаагүй дараах төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг /мян.төг/		Тайлбар
		Эхлэх	Дуусах	Эхний	Сүүлийн	
Боловсролын сайд	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2019	2024	1,618.6	2,471.3	2026 оны төсвийн тухай хуульд 973.9 сая төгрөг баталсан
Зам, тээврийн сайд	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/	2022	2024	5,355.6	5,337.9	Үлдэгдэл санхүүжилт 3,086.7 сая төгрөгийг барьцаа дансанд шилжүүлсэн.
ХХААХҮ С	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2018	2024	2,200.0	2,408.1	Үлдэгдэл санхүүжилт 504.1 сая төгрөгийг барьцаа дансанд шилжүүлсэн.
Нийт				9,174.2	10,217.3	-

Тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр эрх шилжин хэрэгжих ТАХ байхгүй боловч Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн үргэлжлэл ажлыг НТШ-ын аргаар зохион байгуулсан байна.

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Баянтал сумын 3.4км авто зам /Говьсүмбэр, Сүмбэр сум/	18
2	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	18

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан ТАХ-ний жагсаалт	8
2	Говьсүмбэр аймгийн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд өгсөн үнэлгээ	9
3	Сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан байх шаардлагыг хангаагүй байхад төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалт	10
4	Эрх шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний санхүүжих дүн	11
5	Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд батлагдсан ТАХ-ний үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт	12
6	2025 онд олгосон санхүүжилт	14
7	Эрх шилжин хэрэгжиж буй төсөлд тавих захиалагчийн хяналт	16
8	Зураг төсөв зохиогчийн хяналт хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт	16
9	Улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан төсөл	17
10	Мэдээллийн самбарыг ил тод байршуулаагүй төслийн жагсаалт	18
11	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөсөн үр дүн, гүйцэтгэлийн үзүүлэлт	19
12	Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт	20

БҮЛЭГ А

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлэх үйл явц хангалтгүй, олон нийтээр хэлэлцүүлж санал авах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

А.1.1 Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10¹-г заасан шаардлагыг хангасан байх хуулийн зохицуулалттай байна. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймагт хэрэгжихээр баталсан 10 төсөл, арга хэмжээний 6 буюу 60 хувь нь улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан ТАХ-ний жагсаалт:

Хүснэгт 1

(сая төгрөгөөр)

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсвийн ерөнхийлөн захирагч	2025 оны төсөвт өртөг	Санхүүжих дүн	Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө
1	XII.1.1.131	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/	БОЛОВСРОЛЫН САЙД	2,769.3	-	3.1.5
2	XII.1.1.52	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 5 дугаар сургууль/	БОЛОВСРОЛЫН САЙД	12,867.1	4,496.1	3.1.4.
3	XII.1.1.57	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал, /Говьсүмбэр, Сүмбэр сум, 1 дүгээр сургууль/	БОЛОВСРОЛЫН САЙД	7,811.3	4,491.3	3.1.4.
4	XII.1.1.98	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 120 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум, 6 дугаар цэцэрлэг/	БОЛОВСРОЛЫН САЙД	3,001.4	2,999.4	3.2.1.1.
5	XIII.4.1.2	Ахмадын өргөөний барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	2,588.3	1,257.2	-
6	XIV.1.1.47	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	4,619.3	2,282.8	-
7	XIV.1.1.68	Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Чойр-Их залаат овооны ар хүртэлх хатуу хучилттай авто замын эхний үе шат /Говьсүмбэр/	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	17,989.8	9,992.6	1.5.2.10.
8	XV.1.1.28	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	12,430.3	4,169.1	-
9	XV.2.1.8	Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	12,099.6	4,118.9	-
10	XIX.1.20	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц, 2 дугаар хэлхээ /Говьсүмбэр, Сүмбэр сум/	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	11,575.6	4,579.4	2.1.1.4

(Эх сурвалж: Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө)

¹ 6.10.Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна: 6.10.1.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх;

6.10.2.санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх;

6.10.3.улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

6.10.4.орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх.

А.1.2 Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймагт шилжих 10 төсөл, арга хэмжээ барилга байгууламж ангилалд батлагдсан бөгөөд цахим систем, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна.

А.1.3 Мөн дараа онд хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах арга хэмжээг төлөвлөөгүй байна.

А.1.4 Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж, төлөвлөх зохицуулалттай байна.

Аймгийн ТЕЗ уг журмын дагуу Монгол Улсын 2025 оны төсөвт тусгуулан шинээр хэрэгжүүлэх 22 төсөл, арга хэмжээний саналыг <https://pimis.publicinvestment.gov.mn> цахим системд бүртгэн аймгийн Засаг даргын 2024 оны Б/701 тоот албан бичгээр холбогдох салбарын төсвийн ерөнх ийлөн захирагчдад хүргүүлсэн байна. Салбарын ТЕЗ-даас Сангийн яаманд 9 төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлсэн боловч шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна.

Улсын төсөвт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ батлагдаагүй шалтгааныг авч үзэхэд дараах нөхцөл байдал илэрсэн. Үүнд: Цахим системээр хийж буй төлөвлөлт холбогдох шалгуур үзүүлэлт, төлөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаж чадаагүйгээс системийн үнэлгээгээр бага оноо авсан байна.

Аудитаар цахим системд оруулсан 22 төсөл арга хэмжээнээс Сангийн яам хянасан 11 төсөл арга хэмжээний мэдээлэл, бэлэн байдлын үнэлгээг нэгтгэн дундаж үнэлгээг тооцож үзэхэд Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-д зааснаар тухайн төслийн бэлэн байдлыг 100 хувь үзвэл 38.7 хувийн үнэлгээ авсан байна.

Хүснэгт 2

Говьсүмбэр аймгийн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд өгсөн үнэлгээ

Д/д	Шалгуур үзүүлэлт	Жин	Оноо	Авбал зохих	Оноо (Аймаг / Нийслэл, Улсын агентлаг)	Оноо (ТЕЗ)	Оноо (СЯ)
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтуудтай уялдсан эсэх	1.5	5	7.5	2.4	2.6	2.6
2	Олон нийтийн санал авсан эсэх	2	5	10	3.8	3.6	3.6
3	Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол тооцсон эсэх	3	5	15	8.5	5.7	5.7
4	Төслийн хүчин чадлын ашиглалт	1.5	5	7.5	4.6	2.9	2.9
5	Төсөл хэрэгжсэний дараа үйл ажиллагааг нь үр ашигтай тогтвортой удирдах туршлага, чадавх байгаа эсэх	2	5	10	6.0	3.5	3.5
6	Төслийн нийт зардлыг бүрэн тооцсон эсэх	3	5	15	9.5	6.0	6.0
7	Төсөлтэй холбоотой ашиглалтын хугацааны зардал, түүнийг санхүүжүүлэх санал	1	5	5	3.1	1.8	1.8
8	Төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэл	1	5	5	3.0	1.7	1.7
9	Төслийн зураг төсөв, ТЭЗҮ хийгдсэн эсэх	2.5	5	12.5	8.1	5.7	5.7
10	Эрчин хүчний хэмнэлттэй, ногоон хөрөнгө оруулалт эсэх	2.5	5	12.5	4.2	5.2	5.2
Нийт		20		100	53.1	38.7	38.7

(Эх сурвалж Publicinvestment.gov.mn)

Хүснэгтээс харахад төсөвт тусган хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бодлогын баримт бичгийн уялдаа холбоо сул, эдийн засаг нийгмийн ач холбогдлыг нь бодитой тооцоогүй, олон нийтээр хэлэлцүүлж санал аваагүй, ашиглалтын зардал, түүнийг санхүүжүүлэх саналыг бүрэн бэлтгээгүй, эрсдэлийн хүчин зүйлийн нөлөөлөл өндөр байгаа нь үнэлгээг бууруулах үндэслэл болж байна.

Мөн “Дулааны станцын бохир усны шугам ажил” нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд “Дулааны станцын ариутгах татуурга” нэртэйгээр 727.4 сая төгрөгөөр батлагдаж хэрэгжсэн боловч аймгийн ТЕЗ-ийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний саналд 325.8 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусган Барилга хот байгуулалтын сайдад хүргүүлжээ. Энэ нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хэрэгжүүлж буй дотоод хяналт сул, улсын төсөвт тусган хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үр ашиг, ач холбогдлоор нь эрэмбэлэх үйл явц хангалтгүй байгаатай холбоотой байна.

Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудын оролцоог хангаж олон нийт танилцуулж санал авах, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох, төслийн өртөг зардал, төсөлтэй холбоотой зардлыг тооцож Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

А.2. Төлөвлөсөн төсөл арга хэмжээний 10 хувь нь сүүлийн 2 жилийн хугацаанд магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байна.

А.2.1 Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд тусган шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж аймгийн Засаг даргаас салбарын ТЕЗ-д илгээсэн 51,883.5 сая төгрөгийн 22, салбарын ТЕЗ-аас Сангийн яаманд илгээсэн 16,540.6 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнээс 4,455.6 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журамд заасан барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байна.

Хүснэгт 3

(сая төгрөгөөр)

Сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан байх шаардлагыг хангаагүй байхад төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төслийн нэр	Зураг төсвийн огноо	МБТӨртөг	Зураг төсвийн гүйцэтгэгч	Зураг төсвийн зардал
1	Дулааны станцын бохир усны шугамын ажил	2020.02.10	325.8	Баяр мега сервис ХХК	10.9
2	Шивээговь сумын бохирын гол коллектор цэвэрлэх байгууламж /Говьсүмбэр, Шивээговь сум/	2021.03.21	4,129.8	Гидро дизайн инноваци ХХК	15.0
Нийт			4,455.6		25.9

(Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын төсвийн санал, зураг төсөв, магадлалын дүгнэлт) Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн шаардлагыг хангахын тулд тэдгээр ажлын зураг төсвийг улсын төсөвт батлагдах эсэхээс нь үл хамааран жил бүр зураг төсвийн компаниудаар гүйцэтгүүлж, төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулж байна. Тухайлбал:

Аймгийн ТЕЗ-аас 2025 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 22 төсөл, арга хэмжээний зураг төсвийн зардалд 2020-2025 онд улс, орон нутгийн төсвөөс 491.4 сая төгрөгийг зарцуулсан боловч Монгол Улсын 2025 оны төсөвт ямар нэгэн төсөл арга шинээр хэрэгжихээр батлагдаагүй байна. Дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс үзнэ үү.

Цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, төсөл, арга хэмжээ батлагдах нь тодорхой болсон тохиолдолд зураг төсөв, магадлалын дүгнэлтийг боловсруулж төсөвт тусгах арга хэмжээг

авснаар үр ашиггүй зарцуулагдаж буй мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг сайжруулах боломжтой тул Үндэсний аудитын газарт дээрх саналыг уламжлах, шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөхгүй байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

А.2.2 Монгол Улсын 2025 оны төсөвт Говьсүмбэр аймагт цахим систем, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна.

А.2.3 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5²-т шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд нь тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй төсөв хуваарилж, гурван жилийн дотор санхүүжүүлж дуусгах гэж заасан.

А.2.4 Говьсүмбэр аймагт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ батлагдаагүй бөгөөд эрх шилжин хэрэгжихээр батлагдсан 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тэнцүү хуваарилсан хэмжээнээс нь багагүй байхаар тооцож санхүүжих дүнг төлөвлөсөн байна.

Эрх шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний санхүүжих дүн

Хүснэгт 4

(сая төгрөгөөр)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тэнцүү хуваарилах дүн	Зөрүү
1	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	2020	2025	12,430.3	4,169.1	4,143.4	25.67
2	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/	2022	2025	2,769.4	-	923.1	(923.13)
3	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/	2024	2025	4,619.3	2,282.8	2,309.7	(26.85)

(Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль)

Хүснэгтээс харахад Шивээговь сумын цэцэрлэгийн барилгад 923.1 сая төгрөгийг хуваарилах ёстой боловч 2024 тухайн барилгын ажлыг гүйцэтгэгч компани өөрийн хөрөнгөөр төлөвлөсөн хугацаанаас нь өмнө 100 хувь гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн тул Боловсролын сайд төсөвтөө зохицуулалт хийж санхүүжилтийг 2024 онд бүрэн олгосон байна. Харин Баянтал сумын 3.4 км замын эхний санхүүжилтийг 2024 онд тэнцүү хуваарилах дүнгээс нь илүү өгсөн тул 2025 онд үлдэгдэл санхүүжилтийг төлөвлөжээ.

А.2.5 Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг баталсан байна.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд батлагдсан ТАХ-ний үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

Хүснэгт 5

² 29.3.5.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;

№	ТЕЗ-ийн нэр	Хөтөлбөр	Хөтөлбөрийн зорилг, хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилгот түвшин
1	БС	71801 Сургуулийн өмнөх боловсрол	Сургуулийн өмнөх боловсролд бүх хүүхэд хамрагдах тэгш боломж бүрдүүлнэ.	28.1.2.3. Сургуулийн өмнөх боловсролын стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан цэцэрлэг	хувь	2021	60	66
2	ССАЖЗС	71702 Соёл, урлаг	Соёлын дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	35.1.2.1. 1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудал	тоо	2018	32	35
3	ЗТС	71107 Зам тээврийн бодлого, удирдлага	Байнгын ашиглалтад оруулах авто замын нийт хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	26.1.3.1. Ашиглалтад оруулах олон улс, улсын болон орон нутгийн чанартай авто зам	км	2024	1,100	1245.61

Говьсүмбэр аймагт эрх шилжин хэрэгжиж буй 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлж төлөвлөсөн байна.

БҮЛЭГ Б

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

Б.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу, хугацаанд нь зохион байгуулсан байна.

Б.1.1 Тайлант хугацаанд дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчаас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ батлагдаагүй.

Харин Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуульд батлагдсан боловч гүйцэтгэгч компанийн үйл ажиллагаанаас шалтгаалан ажил нь зогссон жижиг дунд үйлдвэрийн барилгын ажлын гэрээг цуцалсан бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4³-т заасны дагуу цахим системд нийтэлсэн байна.

Б.1.2 Захиалагч нь 2025.06.23-ны өдрийн Б/652 тоот албан бичгээр тус ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг худалдан авах ажиллагааны газар хүргүүлж, аймгийн Засаг даргын 2025.07.01-ний өдрийн А/272 дугаар захирамжаар үнэлгээний хороог нь байгуулжээ.

Б.1.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1⁴ -т заасны дагуу захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулж батлахаар заасан. Уг төсөл нь 2018-2024 оны хооронд хэрэгжиж байсан бөгөөд барилгыг эхний ээлжинд ашиглалтад оруулахад шаардлагатай ажлын тоо хэмжээ, онцлогийг тендерийн баримт бичигт тусгаж тендер шалгаруулалтыг 2026.07.01-ний өдөр цахим системээр зарласан байна.

Б.1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1⁵-т төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 05 дугаар сарын 31-ний дотор бүрэн дуусгах гэж заасан боловч тухайн төслийн гүйцэтгэгч компани гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тул захиалагч гэрээг цуцалсан байна.

³ 44.4.Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ.

⁴ Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.

⁵ 13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

Төслийг үргэлжлүүлж дуусгах нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор барьцаа дансанд байршуулсан үлдэгдэл ажлын санхүүжилтээр худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Энэ нь Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажлыг дуусгахад дээрх худалдан авах ажиллагааг зайлшгүй зарлах шаардлага үүссэнтэй холбоотой бөгөөд барилга ашиглалтад орсноор олон жил зогсонги байдалтай байсан төслийг хэрэгжүүлж дуусгасан үр дүнтэй ажил болсон байна.

Б.1.4 Тус төслийн гүйцэтгэгчээр Өрнөх бьютдинг ХХК шалгарсан бөгөөд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангасан оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.

Б.2 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхэд хяналт, шалгалт хийгээгүй байна.

2025 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1 төслийн худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол гараагүй бөгөөд цахим системийн бүртгэл, мэдээлэлд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

БҮЛЭГ В

ЗАРИМ ТӨСӨЛ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ, ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.

В.1 Өмнөх оноос дамжин хэрэгжиж буй зарим төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд батлагдсан 3 төсөл, арга хэмжээнээс 2 нь хуульд заасан төлөвлөсөн хугацаандаа хэрэгжсэн байна.

Төлөвлөсөн хугацаандаа хэрэгжсэн ТАХ:

1. Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/,
2. Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/

Мөн Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд батлагдаагүй “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих барилга”-ын ажлыг барьцаа дансанд байршуулсан 504.1 сая, орон нутгийн төсвөөс 213.0 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлж 2025 онд хүлээн авсан байна.

Төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй ТАХ:

1. Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/

Тус төсөл нь Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд 12,430.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4,169.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй батлагджээ. Тайлант хугацаанд гүйцэтгэгч компани 1,775.5 сая төгрөг буюу 43 хувийн гүйцэтгэл гаргаж санхүүжилт авсан бөгөөд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй, гэрээг сунгасан байна.

2. Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум-5,355.6/ ажлын гүйцэтгэл-27 хувь /2022-2024/

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд батлагдаагүй бөгөөд гүйцэтгэгч компанийн үйл ажиллагаа, ажлын тоо хэмжээ, зураг төсөвт өөрчлөлт оруулах шаардлага үүссэн зэргээс шалтгаалан тус төсөл төлөвлөсөн хугацаандаа хэрэгжих боломжгүй болж зогссон бөгөөд барьцаа дансанд байршуулсан 2024 оны санхүүжилт 3,086.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

3. “Сүмбэр сумын 150 ортой Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга”-ын ажлын төсөвт өртгийг баталгаажуулан Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуульд 973.9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн байна.

Төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг үр дүнтэй хийгээгүй, гүйцэтгэгч байгууллагууд гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй байхад тухай бүр хариуцлага тооцдоггүй байдал нь хэрэгжилт, үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байна. Иймд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч дээрх төслүүдийн гүйцэтгэл, үр ашгийг сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

В.1.2 Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд батлагдаж аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжсэн 2 төсөл арга хэмжээнд 4,058.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч компаниудын бодит гүйцэтгэлд нь үндэслэн олгосон байна.

2025 онд олгосон санхүүжилт

Хүснэгт №6

(сая төгрөгөөр)

№	ТАХ-ний нэр	ТАХ-ний төсөвт өртөг	Гэрээний дүн	Өмнө олгосон санхүүжилт	2025 онд санхүүжих дүн	Гүйцэтгэлээр олгосон дүн	Үлдэгдэл
1	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	12,430.2	12,430.2	8,213.3	4,169.1	1,775.5	2,393.6
2	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/	4,619.3	4,619.3	2,336.5	2,282.8	2,282.7	0.1
3	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/	2,769.4	2,769.3	2,769.3	0.0	0.0	0.0
4	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга	2,611.8	717.0	2,107.8	717.0	504.0	213.0
Нийт		22,430.7	20,535.8	15,426.9	7,168.9	4,562.2	2,606.7

(Эх сурвалж: pimis.publicinvestment.gov.mn, дансны хуулга, гүйцэтгэл)

Хүснэгтээс харахад: Дуу бүжгийн боржигин чуулгын барилгын ажлын санхүүжилтэд 4,169.1 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 1,775.5 сая төгрөгийг авч 2,393.6 сая буюу 57.41 хувийг төсөвт буцаан татуулсан байна. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилгын ажлын санхүүжилт 213.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон бөгөөд 2022 онд илүү гүйцэтгэл гаргаж санхүүжилт авсан асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэхээр болсон байна.

В.1.3 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцад ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсөвт өөрчлөлт оруулсан байна. Барилга хот, байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Барилга байгууламжийн барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт хийх гэрээний үлгэрчилсэн загвар”-ын 2.3.7⁶, захиалагч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний 10.12⁷-т заасны дагуу төслийг хэрэгжүүлэх явцад ажлын тоо хэмжээ болон материалд өөрчлөлт оруулсан боловч магадлалаар баталгаажуулсан өөрчлөлтийн төсөв /нэмэгдсэн, хасагдсан/, захиалагч болон зохиогч байгууллагуудтай зөвшилцөл хийсэн албан бичиг, хурлын тэмдэглэл зэргийг баримт бичигт хавсаргаагүй байна. Тухайлбал:

- Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/
 - Явган замыг өнгөт хавтангаар хийх байсныг асфальт бетон хучилттай болгосон.
 - Сургуулийн авто зогсоолын байршлыг өөрчлөн тамгын газрын урд шилжүүлсэн.

⁶ 2.3.7 Батлагдсан зураг төсөлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүсвэл захиалагч болон, зохиогч бусад байгууллагатай тохиролцоо ажлыг гүйцэтгэнэ.

⁷ 10.12 Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд өөрчлөлт оруулахгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.

- Хороолол доторх авто замын трасс орон сууцны үүдээр дайрч өнгөрөх байсныг 2 метр газарт шилжүүлсэн.
- Авто зам дээгүүр ус давуулах далан төлөвлөсөн байсныг ус зайлуулах хоолой болгож өөрчилсөн. Үүнээс шалтгаалан замын түвшин нэмэгдсэн. Тохиромжгүй ул хөрсийг сольсон.

2. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/

- Барилгын дулааны шугамыг эх үүсвэрээс бус усан спорт сургалтын төвөөс худаг гаргаж татсан.
- Цахилгаан хангамжийн ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулж тоо хэмжээ нэмэгдсэн.
- Өрөөний зохион байгуулалтад өөрчлөлт оруулж тоо хэмжээг багасгасан.

Иймд өөрчлөлт орсон ажлын тоо хэмжээ, зураг төсөв зохиогчоор баталгаажуулсан төсөв, зохиогч болон захиалагч байгууллагатай хийсэн зөвшилцлийн бичиг, хурлын тэмдэглэл зэргийг гүйцэтгэлийн баримт бичигт хавсаргаж зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

V.1.4 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна. Тайлант хугацаанд ашиглалтад хүлээн авсан “Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/” төслийн гэрээг дүгнэж ашиглалтад хүлээн авсан байна.

Харин Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/ төслийн гэрээний хугацаа 2025.11.30-нээр дуусгавар болсон боловч ажлын гүйцэтгэл 75 орчим хувьтай, 2025 онд санхүүжих дүнгийн 42.5 хувийг авсан байна. Тус төслийн гүйцэтгэгч Хөшиг уул ХХК-иас гэрээ сунгах хүсэлтийг 2026.03.12-ны өдрийн 11 дугаартай албан бичгээр ирүүлсэн ба захиалагч гэрээний хугацааг 2026.12.10 хүртэл сунгасан байна.

Энэ нь гүйцэтгэгч, захиалагчтай байгуулсан ГСАОНӨГ/202308030 гэрээ болон 2024.09.06-ны өдрийн гэрээ сунгалт, Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1⁸-т заасныг тус тус зөрчсөн тул гэрээг дүгнэхдээ гэрээний сунгалтгүй, хугацаа хэтэрсэн хоногоор алданги тооцох, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах албан шаардлагыг өгөхөөр шийдвэрлэв.

V.2 Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

V.2.1 Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.32⁹, 37 дугаар зүйлийн 37.1.5¹⁰-т заасны дагуу барилгын ажлыг зураг төсөл, норм норматив, техникийн шаардлагын дагуу баригдаж буй эсэхийг зураг төсөв зохиогч болон захиалагчийн хяналтын байгууллага хяналт хэрэгжүүлэх хуулийн зохицуулалттай бөгөөд захиалагч нь барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж, ил далд ажлын акт, фото зургаар баталгаажуулсан байна.

Захиалагч буюу аймгийн Засаг даргын орлогч ГХБХБГ-тай захиалагчийн хяналтын 2025-01 дугаартай гэрээг 2025.02.12-ны өдөр байгуулсан байна.

Эрх шилжин хэрэгжиж буй төсөлд тавих захиалагчийн хяналт

Хүснэгт №7

(сая төгрөгөөр)

№	ТАХ-ний нэр	Захиалагчийн хяналтын хэрэгжүүлсэн	Гэрээний дүн	Хяналт хэрэгжүүлсэн эсэх		Олгосон санхүүжилт
				Тийм	Үгүй	
1	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	ГХБХБГ	232.0	Тийм	163.9	

⁸ 350.1.1.гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх;

⁹ 4.1.32."зураг төсөл зохиогчийн хяналт" гэж барилгын ажил, зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн дагуу гүйцэтгэж байгаа эсэхийг зохиогчоос хянаж байгаа үйл ажиллагааг;

¹⁰ 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтэц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг харууцах;

2	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/	ГХБХБГ, Б.Бадар-ууган	63.4	Тийм	63.4
3	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	ГХБХБГ	8.7	Тийм	8.7
Нийт			304.1	3	236.0

(Эх сурвалж: Захиалагчийн хяналтын гэрээ, хяналтын тайлангууд, pimis.publicinvestment.gov.mn)

Зураг төсөв зохиогчийн хяналт хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №8

(сая төгрөгөөр)

№	ТАХ-ний нэр	ЗТ-ийн зохиогчийн нэр	Гэрээний дүн	Хяналт хэрэгжүүлсэн эсэх		Олгосон санхүүжилт
				Тийм	Үгүй	
1	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	Ориент плюс ХХК	116.0	Тийм		82.0
2	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/	Ихэр мөнх ХХК	0		Үгүй	0
3	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	Нарлаг хөхийн ХХК	4.3	Тийм		4.3
Нийт			120.3	2	1	86.3

(Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын ажлын гэрээ, хяналтын тайлан, pimis.publicinvestment.gov.mn)

Хүснэгтээс харахад Баянтал сумын 3.4 км автозамын ажилд зураг төсөв зохиогч хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь тус ажлыг гүйцэтгэх гэрээнд зураг төсөв зохиогчоор хяналт тавиулах зардлыг тусгаж батлаагүйтэй холбоотой бөгөөд ГХБХБГ-аас Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу хяналтын инженертэй гэрээ байгуулан хяналт хэрэгжүүлсэн байна.

В.2.2 Барилгын материал, бүтээгдэхүүн нь Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1¹¹, 13.1.1, 13.1.2, 13.1.3, 13.1.4¹²-г заасан шаардлагыг хангасан байх хуулийн зохицуулалттай байна. ГХБХБГ-аас барилга байгууламжид ашиглаж буй материал, бүтээгдэхүүн шаардлагад нийцсэн эсэхэд ажлын үе шат бүрт хяналтыг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/ төсөлд ашигласан бетон хашлага, ул хөрсний нягтаршил, хөлдөлтөөс хамгаалах үе, цементээр бэхжүүлсэн суурь, далангийн дүүргэлт, өнгө болон суурь асфальтбетон зэргээс дээж авч Нийслэлийн замын хөгжлийн газрын материал шинжилгээ, туршилт судалгааны итгэмжлэгдсэн лабораторт баталгаажуулсан байна. Мөн далангийн түвшнийг шалгаж, ажлын өндөр, үеийн зузааныг тодорхойлж фото зургаар баталгаажуулсан байна.
- Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/ төсөлд ашигласан цемент, арматур, дүүргэгч материал, дулаалгын эрдэс хөвөн, өргийн ажилд хэрэглэх хөнгөн блок, бетоноос тус тус дээж авч барилгын хөгжлийн төвийн лабораторийн шинжилгээнд хамруулж баталгаажуулсан байна.
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/ төсөлд ашигласан гадна дулаалгын полистрол хавтангаас дээж авч шинжилгээнд хамруулсан бөгөөд шавардлагын болон заслын ажилд хяналт хэрэгжүүлсэн байна. Харин дотоод засал болон сантехникийн шугам хоолой, цахилгааны монтаж, агааржуулалтын систем, шал, будаг, замаск, эмульс, плитаны гарал үүслийн баримт бичгийг гүйцэтгэлийн болон хяналтын тайланд хавсаргаагүй байна.

¹¹ 13.1.Барилга байгууламжид ашиглах барилгын материал, бүтээгдэхүүн дараахь шаардлагыг хангасан байна:

¹² 13.1.1.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, зураг төслийн шаардлагыг бүрэн хангасан байх;

13.1.2.хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй байх;

13.1.3.чанарыг баталгаажуулсан гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн батламжтай байх;

13.1.4.чанарын шаардлага хангасан зориулалтын сав, баглаа, боодол, хаяг, шошготой байх.

Цаашид барилгын ажилд хэрэглэж буй материал, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын гэрчилгээг гүйцэтгэлийн болон хяналтын тайланд бүрэн хавсаргах зөвлөмжийг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

В.2.3 Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс нь 2025 онд ашиглалтад хүлээн авсан 2 төслийг холбогдох заавар, журмын дагуу хянаж ашиглалтад хүлээн авсан байна.

Улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан төсөл

Хүснэгт №9

(сая төгрөгөөр)

Ашиглалт хүлээн авсан ТАХ-ний нэр	Комисс томилсон захирамжийн дугаар	Комиссын гишүүдийн тоо	Ашиглалтад хүлээн авсан огноо	Актын №
1 “Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/”	2025.07.30 А/298	15	2025.07.30	01
2 “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/”	2025.06.19 А/257	14	2025.11.24	08

(Эх сурвалж: Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт, хурлын тэмдэглэл)

В.2.4 Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2¹³, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол Улсын үндэсний стандарт MNS7023:2023¹⁴-аар улс, орон нутгийн төсвөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарт байршуулах загвар аргачлалыг тодорхойлсон байдаг.

Аудитаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн мэдээллийн самбар байршуулсан байдлыг шалгахад дараах төслийг хэрэгжүүлэгч байгууллагууд мэдээллийн самбарыг байршуулаагүй байна.

Мэдээллийн самбарыг ил тод байршуулаагүй төслийн жагсаалт

Хүснэгт №10

№	Төсөл, арга хэмжээний нэр
1	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал, /Говьсүмбэр, Сүмбэр сум, 1 дүгээр сургууль/
2	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/-Шаардлага хангаагүй.
3	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 120 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум, 6 дугаар цэцэрлэг/
4	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/
5	Сургуулийн барилга, 320 суудал /Говьсүмбэр, Шивээговь сум, 3 дугаар сургууль/

Иймд хууль тогтоомжоор нийтэд ил тод мэдээлэхийг шаардсан хөрөнгө оруулалтын төслийн талаарх мэдээллийн самбарыг ил тод байршуулах, хэрэгжилтэд хяналт тавих зөвлөмжийг аймгийн ГХБХБГ-т өгөхөөр шийдвэрлэв.


В.3 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлээгүй, бүрэн хүчин чадал зориулалтын дагуу ашиглаагүй байна.

В.3.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилгыг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, хүчин чадал, зориулалтын дагуу ашиглаагүй байна.

¹³ 37.1.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.10, 8.6.11-д заасны дагуу барилга байгууламж болон үйл ажиллагааныхаа талаархи иж бүрэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байрлуулах;


¹⁴ Энэхүү стандартаар улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих инженерийн барилга байгууламжийн барилгын ажил, гадна тохижилтын ажил бусад бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд хэрэглэх мэдээллийн самбар байршуулах, тэдгээрийн нэгдсэн загвар, аргачлалыг тодорхойлно.

Төсвийн хөрөнгөөр бий болсон автозамын ажлыг Баянтал сумын ЗДТГ бүртгэж зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.



Баянтал сумын 3.4км авто зам /Говьсүмбэр, Сүмбэр сум/

Харин жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилгыг данс бүртгэлд бүртгээгүй, анхны зориулалт, хүчин чадлаар нь бүрэн ашиглаагүй байна. Тухайлбал: Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилгад тоног төхөөрөмж суурилуулж, худалдаа, бизнес эрхлэгчдийг дэмжих зориулалттай боловч одоогийн байдлаар тус зориулалтаар ашиглаагүй, 2 дугаар давхрыг Чойр хотын захиалагчийн ажлын албаны албан өрөөний зориулалтаар ашиглаж байна.



Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2¹⁵, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3¹⁶, 2.3.1.5¹⁷, 4.8.30¹⁸-г заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилгыг данс бүртгэлд бүртгэх, зориулалтын дагуу бүрэн ашиглах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

В.3.2 Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, бодлогын зорилтын үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан тайлагнасан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилт, Говьсүмбэр аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг холбогдох шалгуур үзүүлэлтээр үнэлж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэгтгэн тайлагнасан байна. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2026.03.31-ний өдрийн 02 дугаар тогтоолоор Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар 85.1 хувьтай буюу үр дүнтэй хэрэгжсэн гэж үнэлсэн байна.

¹⁵ 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

¹⁶ 2.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ;

¹⁷ 2.3.1.5.төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлэн тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, бүртгэлийг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих, харнуцах;

¹⁸ 4.8.30.Эцсийн буюу бүрэн санхүүжилтийг авахад тухайн төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргах бөгөөд цахим системд баталгаажуулсан байна;

В.3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж хэрэгжүүлснээр төлөвлөсөн бодлогын зорилтот үр дүнд хүрсэн эсэхийг суурь түвшинтэй харьцуулж тайлагнасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөсөн үр дүнд, гүйцэтгэлийн үзүүлэлт

Хүснэгт №11

(сая төгрөгөөр)

№	Бодлогын баримт бичгийн нэр	Хамрах хугацаа	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тоо	Тухайн жилийн зорилтот түвшин	Тухайн жилийн гүйцэтгэлийн түвшин	Хэрэгжилтийн хувь
1	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2025	13	68%	64%	94%
2	Говьсүмбэр аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө	2025	14	94%	74%	72.3%

(Эх сурвалж: Аймгийн ХШҮХ-ийн тайлан)

Хүснэгтээс харахад аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ тухайн жилийн зорилтот түвшнийг 94 хувьтай, хөгжлийн жилийн төлөвлөгөөг 72.3 хувьтай хэрэгжсэн гэж Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс дүгнэсэн байна.

Хөгжлийн жилийн төлөвлөгөө болон засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөө харилцан адилгүй байдлаар үнэлэгдэж байгаа нь шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг нь харилцан адилгүй тогтоосонтой холбоотой байна.

В.3.4 Өмнөх аудитын шийдвэрийг 95.8 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар өгсөн аудитын шийдвэр хэрэгжилт авч үзэхэд дараах байдалтай байна.

Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт

Хүснэгт №12

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын шийдвэр		Биелэлт		
	Тоо	Дүнд	Тоо	Дүнд	Хувь
Акт	1	2.0	1	2.0	100%
Албан шаардлага	6	535.2	5	255.8	83.3%
Зөвлөмж	2	0	2	0	100%
Хариуцлага тооцох санал	1	151.9	1	151.9	100%
Нийт дүн	10	689.1	2	409.7	95.8%

Өмнөх аудитаар Политехник коллежид худалдан авсан трактор ашиглалтын шаардлага хангаагүй, цас түрэгч дагалдах хэрэгслүүд нь техникийн тодорхойлолтод нийцээгүй тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна. Хүчин төгөлдөр болсон аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй нь хариуцлага тооцох үндэслэл болох тул дээрх албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллах шаардлагатай байна.

Аудитаар нийт 2,393.6 сая төгрөгийн 7 зөрчил илрүүлж, 2,393.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 5 зөвлөмж өгч, Үндэсний аудитын газарт уламжлах 2 санал хүргүүлэхээр шийдвэрлэв.

ДУГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлэх үйл явц хангалтгүй, олон нийтээр хэлэлцүүлж санал авах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.
2. Төлөвлөсөн төсөл арга хэмжээний 10 хувь нь сүүлийн 2 жилийн хугацаанд магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байна.

Бүлэг-2

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу, хугацаанд нь зохион байгуулсан байна.
2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхэд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Бүлэг-3

ЗАРИМ ТӨСӨЛ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ, ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.

1. Өмнөх оноос дамжин хэрэгжиж буй зарим төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна.
2. Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн байна.
3. Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлээгүй, бүрэн хүчин чадал зориулалтын дагуу ашиглаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Төсөвт тусган хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бодлогын баримт бичгийн уялдаа холбоог сайжруулах, эдийн засаг нийгмийн ач холбогдлыг нь бодитой тооцох, олон нийтээр хэлэлцүүлж санал авах, ашиглалтын зардал, түүнийг санхүүжүүлэх саналыг бүрэн бэлтгэх
2. Ашиглалтад хүлээн авсан хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгуулж зориулалт хүчин чадлаар нь ашиглах

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт:

1. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад ажлын тоо хэмжээнд зайлшгүй өөрчлөлт оруулсан тохиолдолд холбогдох баримт материалын иж бүрэн байдлыг хангах
2. Барилгын ажилд хэрэглэж буй материал, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын гэрчилгээг гүйцэтгэлийн болон хяналтын тайланд бүрэн хавсаргах
3. Төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу байршуулсан эсэхийг хянах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг **2026 оны 10 дугаар сарын 15-ны** өдрийн дотор ирүүлэх, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд буюу **тайланг гардаж авснаас 30 хоногийн дотор** тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах саналыг Үндэсний аудитын газарт уламжлахаар шийдвэрлэв.

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох тухайлбал: 1 дүгээр шатанд төслийн ач холбогдол хэрэгцээ, нийгэм эдийн засгийн үр ашгийг тооцох, 2 дугаар шатанд зураг төсвийг боловсруулж магадлалаар баталгаажуулах

Зураг төсөв, магадлалын дүгнэлтийг төсөл, арга хэмжээ батлагдах нь тодорхой болсон тохиолдолд боловсруулж төсөвт тусгах арга хэмжээг авснаар зураг төсөвт үр ашиггүй зарцуулагдаж буй мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг сайжруулах боломжтой байна.

2. Олон жижиг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 2-3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төсөвт баталж байна. Энэ хугацаанд барилга байгууламжийн төсөвт өртөг нэмэгдэх, санхүүжилт дараа онд шилжих зэргээр анх төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад орохгүй байх нийтлэг зөрчил гарсаар байна. Иймд цөөн төслийг төсвийн жилд нь багтаан бүрэн санхүүжүүлж, хэрэгжүүлдэг байх саналыг тус тус уламжилж байна.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас/Факс: (976) 7054 3005,
Цахим шуудан: zdtg.gsa@gmail.com,
Цахим хуудас: www.govisumber.gov.mn

2025.04.09 № 8/458
танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА
ТАНАА

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцсан ба тайлангийн төсөлтэй холбоотой санал байхгүй болно.

ОРЛОГЧ ДАРГА



Б.НАРАНБААТАР

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас: 7054 3387, Цахим шуудан: govisumber@gazar.gov.mn,
Цахим хуудас: www.govisumber.gazar.gov.mn

2026.04.09 № 01/161


танай 2026.04.08-ны № 106 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА ТАНАА

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний 2025 оны гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Тайлантай холбоотой санал хүсэлт байхгүй болно.

ДАРГА



Б.ОТГОНЧИМЭГ

4236200187

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 319 тоот, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас/Факс: 976-7054 3033
Цахим шуудан: goviumsumber.onug@gmail.com

2026.04.09 № 44
танай 2026.04.08-ны № 104 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.САРАНТУЯА ТАНАА

“Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл, аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэлтэй танилцаад тайлбар, саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт...хуудастай

ДАРГА



А.ОТГОНТУЯА

2026 on\Albn bic:higl A5

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн саналыг хүлээн авч тайланд дараах байдлаар өөрчлөлт оруулсан. Үүнд:

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилгыг данс бүртгэлд бүртгүүлэх, зориулалтын дагуу бүрэн ашиглах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Монгол Улсын 2025 оны төсөвт тусгуулахаар төлөвлөсөн ТАХ-ний зураг төсөвт орон нутгийн төсвийн хөрөнгөөс зарцуулсан зардлын судалгаа

Хавсралт №1

№	Зураг төсвийн нэр	Төсөвт өртөг	Магадлалаар баталгаажсан төсөвт өртөг	Магадлалаар баталгаажсан огноо	Зураг төсвийн гүйцэтгэгч	Зураг төсвийн зардал	Зураг төсвийг бүртгэсэн
1	Дулааны станцын бохир усны шугамын ажил	325.8	325.8	2020.02.10	Баяр мега сервис ХХК	10.9	АЗДТГ
2	Дуу бүжгийн Боржигин чуулгын 400 хүний суудалтай театрын тайзны технологи, интериер заслын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2,930.2	2,930.2	2023.10.20	Аркосис ХХК	108.7	АЗДТГ
3	Өрхийн Эрүүл мэндийн төвийн барилгын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2,868.6	2,868.6	2024.01.19	Болор төсөл ХХК	20.0	АЗДТГ
4	Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	1,171.0	2,173.6	2023.08.21	Барилга байгууламж ХХК	10.0	
5	Мал эмнэлэгийн контор, лабораторийн барилгын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2,425.4	2,425.4	2024.05.21	Жаргалант хийц ХХК	15.0	АЗДТГ
6	Хорихын 75 айлын гадна шугам сүлжээ, дулааны шугамын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	1,143.7	1,143.7	2023.10.24	Ар төгөл ХХК	12.5	АЗДТГ
7	Усан хангамжийн 125 м3 х2 усан сан цэвэр усны насосны барилга	1,146.5	1,146.5	2024.03.04	Кингсий инженер энл конскракшн консалтинг групп ХХК	3.0	Илчлэг шивээ
8	Сүмбэр сумын 1 дүгээр багийн дан байрнууыг цэвэр суны шугамд холбох ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	418.5	418.5	2022.10.19	Тэмжин ХХК		
9	Шивээговь сумын бохирын гол коллектор цэвэрлэх байгууламж /Говьсүмбэр, Шивээговь сум/	4,129.8	4,129.8	2021.03.21	Гидро дизайн инноваци ХХК	15.0	ШГЗДТГ
10	Шивээговь сумын цэвэр усны эх үүсвэрийн өргөтгөл шинэчлэлийн ажил	1,908.7	1,908.7	2022.10.21	Гидро дизайн инноваци ХХК	15.0	Илчлэг шивээ
11	Хогийн цэгт цахилгаан татах ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	176.4	176.4	2024.03.25	Ингүүмэл эрчим ХХК	15.0	АЗДТГ
12	Сүмбэр сумын 2 дугаар 11 жилийн сургуулийн "Спорт заалны өөрчлөлт, их засвар"-ын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	1,723.6	1,723.6	2023.11.03	Ориент плюс ХХК	31.2	АЗДТГ
13	Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн их засварын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	399.5	399.5	2023.01.27	Ориент плюс ХХК	15.0	АЗДТГ
14	Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн их засварын ажил /Говьсүмбэр, Шивээговь сум/	366.7	366.7	2022.10.27	Кингсий инженер энл конскракшн консалтинг групп ХХК	14.0	АЗДТГ
15	Сүмбэр сум доторх 2.4 км автозамын ажлын засвар /Говьсүмбэр, Сүмбэр сум/	1,440.9	1,440.9	2023.11.20	Арвай нутгийн зам	15.0	АЗДТГ
16	Сүмбэр сум доторх 4.8 км автозамын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	5,454.5	5,754.8	2023.02.28	Ангад ариажих ХХК	49.3	АЗДТГ
17	Сүмбэр сум доторх 2.4 км авто замын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3,888.2	3,888.2	2024.01.19	Монголиан нэйшил хайвэй ХХК	37.0	АЗДТГ
18	Шивээговь сумын доторх 2.5 км автозамын ажил /Говьсүмбэр, Шивээговь сум/	2,169.0	2,169.0	2020.02.17	Ихэр мөнх ХХК		

19	Цэргийн алдрын хөшөөний биеийн тамирын тохижилтын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	1,397.6	2,151.3	2020.04.30	Баяр мега сервис ХХК	3.9	АЗДТГ
20	Сүмбэр сумын 1 , 15 дугаар байрны дундах тоглоомын талбай, газар доорх автомашины зогсоол /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3,300.6	3,300.6	2023.01.27	Ориент плюс ХХК	20.0	АЗДТГ
21	Хаус хорооллын барилгын ажил /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2,253.2	2,253.2	2018.07.09	Ноёдын туурь ХХК	21.0	
22	Хэрлэн голын Хөмөлтэйн 217.6 у/м төмөр бетон гүүрийн ажил	8,788.5	8,788.5	2022.04.14	Тарваченбүүлэн ХХК	60.0	АЗДТГ
Нийт		49,826.9	51,883.5			491.4	

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Говьсүмбэр аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний зорилтот түвшин, гүйцэтгэл

Хавсралт №2

№	Төсөл, арга хэмжээний нэр	АЗДҮАХ -2024-2028			Говьсүмбэр аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө		
		Заалт	Төлөвлөсөн үр дүн	Гүйцэтгэл	Заалт	Төлөвлөсөн үр дүн	Тухайн жилийн гүйцэтгэл
1	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3.3.1.2	50%	55%	1.3.5	100%	80%
2	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 120 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум, 6 дугаар цэцэрлэг/	3.3.1.2	50%	55%	1.3.6	100%	20%
3	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/	2.3.3.4	100%	58.5%	5.2.5	100%	13.5%
4	Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга /Говьсүмбэр/	4.5.2.1	100%	90%	1.5.22	100%	90%
5	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 5 дугаар сургууль/	3.3.1.1	20%	20%	1.3.15	70%	85.7%
6	Сургуулийн барилга, 320 суудал /Говьсүмбэр, Шивээговь сум, 3 дугаар сургууль/	3.3.1.1	20%	20%	1.3.16	100%	66.6%
7	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал, /Говьсүмбэр, Сүмбэр сум, 1 дүгээр сургууль/	3.3.1.1	20%	20%	1.3.17	70%	71.4%
8	Усан бассейны бүхий спорт цогцолборын барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3.2.1.1	60%	70%	1.2.5	70%	70%
9	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Баянтал сум/	2.3.3.4	100%	100%	5.2.6	100%	100%
10	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/				1.4.29	100%	100%
11	Чойр-Мандалговийн хатуу хучилттай авто замын ажлыг ашиглалтад оруулна.	2.3.3.1	100%	95%	5.2.2	100%	95%
12	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц	2.1.1.2	70%	43.9%	4.1.4	100%	45%
13	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц, 2 дугаар хэлхээ /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2.1.1.2	100%	100%	5.1.4	100%	100%
14	Ахмадын өргөөний барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3.1.1.3	100%	100%	3.9.15	100%	100%
	Дундаж хэрэгжилт		68%	64%		94%	74%



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/10

Чойр

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 21 дүгээр зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь заалт, 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, "Эрх шилжүүлэх тухай" 2025 оны А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг ахлах аудитор (Б.Дарханбат)-д даалгасугай.

3. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилган, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Т.Бат-Эрдэнэ), Бүс, орон нутгийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (М.Анхбаяр), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Б.Отгончимэг) нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (Б.Дарханбат)-т үүрэг болгосугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг)-т даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Г.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

D:\DOTOOD AJILITUSHAAL.doc

4225040021